

**ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ШИНЭЧЛЭН
НАЙРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН
СУДАЛГАА**

2024 он

Удиртгал

Монгол Улсын Их Хурлаас Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийг 2004 онд баталж даатгалын мэргэжлийн оролцогчдын хяналт, зохицуулалтуудыг тодорхойлсон бөгөөд өнгөрсөн хугацаанд зарчмын шинж чанартай өөрчлөлтүүдийг оруулаагүй болно.

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.3.10-т “Технологид суурилсан даатгалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” батлах тухай УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтын 44-т даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж “Даатгалын төлөөлөгч, зуучлагчийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийн шаардлагыг хасах, даатгалын хохирол үнэлгээний эрх зүйн орчныг холбогдох хуультай уялдуулах, салбарын мэргэжлийн байгууллагын оролцоог хангах, даатгуулагч, даатгагчийн эрх ашгийг хамгаалах, тэнцвэржүүлэх хүрээнд мэргэжлийн оролцогчийн зарим үйл ажиллагааг хязгаарлах зэрэг зохицуулалтыг боловсронгуй болгох” гэж тусгасан байдаг.

Иймд Монгол Улсад даатгалын салбарыг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх, даатгалын мэргэжлийн оролцогчийн эрх зүйн байдлыг оновчтой болгох, даатгалын үйлчилгээг хэрэглэгчдэд мэргэжлийн түвшинд хүргэх, хүлээх үүрэг хариуцлагыг хуульчилж тодорхой болгох хэрэгцээ шаардлагатай байгаа болно.

1. Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал

Даатгалын мэргэжлийн оролцогчдын тухай хууль 2004 онд батлагдаж даатгалын мэргэжлийн оролцогчдын эрх зүйн байдлыг тус хуулиар тогтоон, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулж ирсэн.

Тус хуулиар даатгалын зуучлагч, төлөөлөгч, хохирол үнэлэгчдэд тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих талаар зохицуулсан байдаг бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар ердийн даатгалын зуучлагч 42 компани, давхар даатгалын зуучлагч компани 11, үүнээс 10 банк даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч 24 компани, даатгалын 2416 төлөөлөгч даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна.¹ Даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэлтийн харьцааг 2019-2023 оны байдлаар авч үзвэл дунджаар нийт хураамжийн 21.4 хувийг даатгалын зуучлагч, 27.5 хувийг даатгалын төлөөлөгч тус тус төвлөрүүлсэн². Тайлант хугацаанд 24 даатгалын хохирол үнэлэгч компани 83,4

¹ Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын салбарын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үйл ажиллагааны нэгдсэн тайлангаас [Нэгтгэл-2023--ласт.pdf \(frc.mn\)](http://frc.mn/#/doc/list/131) холбоосоор харна уу.

² Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын салбарын санхүүгийн үйл ажиллагааны нэгдсэн тайлангуудаас, 2019-2023 оны жилийн эцсийн байдлаар <http://frc.mn/#/doc/list/131> холбоосоор харна уу.

тэрбум төгрөг бүхий 44,452 даатгалын хохирлыг үнэлж 4,3 тэрбум төгрөгийн даатгалын хохирол үнэлгээний орлоготой ажиллажээ³.

Ийнхүү даатгалын зуучлагч, төлөөлөгч, хохирол үнэлэгчид нь даатгалын салбарын үйл ажиллагаа, гүйцэтгэлд тодорхой хувь нэмрээ оруулсаар ирсэн ч өнгөрсөн хугацаанд салбарын хөгжлийг шинэ түвшинд хүргэхийн тулд бодлого, зохицуулалтын хүрээнд шийдвэрлэвэл зохих тодорхой асуудлууд, нөхцөл байдлууд бий болсон байна. Тодруулбал:

Даатгалын олон улсын зарчимд мэргэжлийн оролцогч гэдэгт амьдралын, ердийн, давхар даатгалын компаниуд мөн даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагч, хохирол үнэлэгч, актуарч, андеррайтер, аудитын компаниудыг хамааруулдаг. Гэтэл өнөөгийн хууль тогтоомжийн хүрээнд эдгээрээс зөвхөн даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийг даатгалын мэргэжлийн оролцогчид хамааруулсан бөгөөд бусад мэргэжлийн оролцогчдын талаарх зохицуулалт, эрх, үүрэг энэхүү хуулиар тодорхойгүй байна.

Түүнчлэн даатгалын төлөөлөгч, зуучлагчийн үүрэг, хариуцлагын талаар нарийвчлан зохицуулаагүй тул мэргэжлийн оролцогчийн буруутай үйл ажиллагаанаас хохирсон харилцагчийн эрх ашгийг хэн хамгаалах нь тодорхойгүй байна. Иймд даатгалын зуучлагч, төлөөлөгчийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлох хэрэгцээ шаардлага үүсээд байгаа болно.

Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо мэдээг сүүлийн 5 (2019-2023 он) жилийн байдлаар авч үзвэл нийт өргөдөл, гомдлын дунджаар 50 орчим хувь нь даатгалын салбарт хамааралтай байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 51.7 хувийг эзэлж байна. Даатгуулагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлын дийлэнх нь даатгалын нөхөн төлбөртэй холбоотой байсан бөгөөд дээрх өргөдөл, гомдлуудыг судлахад даатгалын компаниудын нөхөн төлбөр олгохоос үндэслэлтэй татгалзсан тохиолдол 2019 онд 68.3, 2020 онд 47.2, 2021 онд 66.2, 2022 онд 61.0, 2023 онд 47,2 хувь байсан байна.⁴ Өөрөөр хэлбэл, үндэслэлтэй татгалзсан тохиолдлын хувь өндөр байгаа нь нэг талаас даатгуулагчдын даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээ, холбогдох хууль эрх зүйн зохицуулалтын талаар мэдээлэл хангалтгүй, даатгалын гэрээний нөхцлүүдтэй бүрэн танилцаж, ойлгоогүй байгааг харуулж байна.

Дээр дурдсанчлан 2016-2023 он хүртэлх хугацаанд төвлөрүүлсэн даатгалын хураамжийн орлогын дүнд даатгалын зуучлагч болон төлөөлөгчийн оролцоо нь дунджаар 55.0 хувь байгаа бөгөөд энэ үзүүлэлтийг өргөдөл, гомдлын судалгааны үр дүнтэй уялдуулан авч үзвэл даатгалын зуучлагч, төлөөлөгч нь олон нийт, даатгуулагчдын даатгалын хэрэгцээгээ зөв үнэлэх, даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг тохируулан сонгох, даатгалын гэрээтэй бүрэн танилцаж, ойлгох зэрэгт чухал үүрэгтэй болох нь харагдаж байна.

Монгол Улсад даатгалын салбарын хөгжил хангалттай бус байгаа нь нэг талаас иргэдийн даатгалд итгэх итгэл, ойлголт хангалтгүй, нөгөө талаас даатгуулагчийн эрэлт хэрэгцээнд суурилсан даатгалын бүтээгдэхүүнийг

³ Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын салбарын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үйл ажиллагааны нэгдсэн тайлангаас, <http://frc.mn/#/doc/list/131> холбоосоор харна уу.

⁴ Санхүүгийн зохицуулах хороо, Өргөдөл гомдлын судалгаа, 2018, 2019, 2020, 2021, 2022, 2023 оны тайлангуудаас тус тус түүвэрлэж, боловсруулав.

даатгагчид мэргэжлийн түвшинд тайлбарлаж ойлгуулах, мэдээлэл хангалттай өгч чадахгүй байгаатай холбон тайлбарлаж болохоор байна. Олон улсын жишгээр даатгалын салбар дах дундын зуучлагчид нь олон нийтэд даатгалын талаарх зөв ойлголтыг түгээх, талуудын эрх ашгийг тэнцвэржүүлэхэд чухал үүрэгтэй нөлөөтэй байдаг.

Санхүүгийн зохицуулах хорооны захиалгаар Эн-Ар-Си-Си судалгааны агентлагаас санхүүгийн зах зээлийн талаарх хэрэглэгчийн итгэлийг үнэлэх, иргэдийн санхүүгийн зах зээлийн оролцоог судлах зорилгоор улсын хэмжээнд 1000 гаруй иргэдийг хамруулан, санамсаргүй түүврийн аргаар хийсэн **“Санхүүгийн зах зээлийн талаарх хэрэглэгчийн итгэлийн судалгаа”**⁵-ны үр дүнгээс харвал иргэдийн 20 гаруй хувь нь сайн дурын даатгалд хамрагддаг байна. Мөн сайн дурын даатгалд хамрагдаагүй шалтгааныг нь тодруулахад:

- Хэрэгцээ шаардлага байхгүй гэдэг шалтгаан хамгийн өндөр буюу дунджаар 34 хувь⁶,
- Даатгалын талаар **мэддэггүй** гэсэн хариулт дараагийн шалтгаан буюу 26.5 хувь,
- Даатгалын хураамж өндөр гэж 15.9 хувь нь тус тус үзсэн байна.

Түүнчлэн тус судалгаагаар иргэдийн санхүүгийн байгууллагуудад итгэх итгэлийг авч үзэхэд арилжааны банкинд итгэх итгэл хамгийн өндөр буюу 80 гаруй хувь итгэдэг, дараа нь даатгал бөгөөд иргэдийн 50 гаруй хувь нь итгэдэг гэж хариулсан байна.

Эн-Ар-Си-Си судалгааны агентлагаас хийсэн судалгааны үр дүнгээс харахад олон нийт, даатгуулагчдын даатгалын тухай мэдлэгийг сайжруулах, даатгалын хэрэгцээгээ зөв үнэлэх, даатгалын бүтээгдэхүүнийг хэрэгцээ шаардлагадаа тохируулан оновчтой сонголт хийх түүнчлэн тэдний даатгалд итгэх итгэлийг нэмэгдүүлэх шаардлагатай, ийнхүү нэмэгдүүлэхэд даатгалын зуучлагч, төлөөлөгчийн үүрэг оролцоо маш чухал болох нь тодорхой харагдаж байна.

Хуулийн дагуу даатгалын төлөөлөгчийг даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий даатгагчийн томилсон буюу эрх олгосон этгээдийг ойлгодог. Гэсэн хэдий ч даатгалын төлөөлөгч нь албан ёсоор даатгагчийг төлөөлөхийн тулд даатгагчаас олгосон зөвшөөрлөөс гадна Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авахаар хуульд заасан нь даатгалын төлөөлөгч үйл ажиллагаагаа зохистой явуулахад илүү хүндрэлтэй бөгөөд үйл ажиллагааны цар хүрээтэй нь харьцуулахад хэт зохицуулалтын хамааралтай байна.

Ихэнхи улс орнуудад, тухайлбал Герман, Австрали, Япон, Бельги, Франц, Итали, Мексик, Нидерланд, Португал, Испани, Швейцарь, Их Британи, Сингапур, Солонгос, Кени улсуудын жишээгээр⁷ даатгалын төлөөлөгчийг зохицуулах

⁵ “Санхүүгийн зах зээлийн талаарх хэрэглэгчийн итгэлийн судалгаа”, Эн-Ар-Си-Си судалгааны агентлаг, 2019

⁶ Хэрэгцээ шаардлага байхгүй гэдэг нь нэг талаас даатгалын хэрэгцээ шаардлагаа үнэлж мэддэггүйтэй холбоотой байж болно (байх магадлалтай).

⁷ Энэхүү тандан судалгааны Бусад улс орны хуулийн онцлох зохицуулалтууд хэсгээс Герман, Австрали, Япон, Белги, Франц, Итали, Мексик, Нидерланд, Португал, Испани, Швейцарь, Их Британи, Сингапур, Солонгос, Кени улсуудын жишээг харна уу. Хуудасны дугаар 11-17.

байгууллагад бүртгүүлж, тавигдах шаардлагыг тусгаж, үйл ажиллагаандаа баримтлах хэм хэмжээг тодорхойлж өгсөн байдаг. Тухайлбал, даатгалын төлөөлөгч нь өөрийн төлөөлж байгаа даатгагчийг заавал дурдах буюу аль даатгагчийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгааг даатгуулагчид мэдэгдэх, мөн даатгагчийн нэрийн өмнөөс гэрээ байгуулж байгаагийн хувьд гэрээ байгуулахтай холбогдон үүсэх хариуцлагыг зөвшөөрөл олгосон даатгагч дангаар хариуцахаар тодорхой зохицуулсан байдаг нь манай зохицуулалтаар бол тавигдах шаардлагуудыг хангасан тохиолдолд энгийн зөвшөөрөл олгодог зохицуулалттай ижил байдаг.

Иймд даатгагчийн албан ёсны зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулж байгаа даатгалын төлөөлөгчид Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл олгож байгаа нь зохицуулалтын хувьд шаардлагагүй буюу төрд ачаалал үүсгэсэн ач холбогдолгүй зохицуулалт болоод байна.

Даатгалын зуучлагч нь мэргэжлийн түвшинд даатгуулагчийн ашиг сонирхол нийцэхүйц гэрээ, хэлцлийг байгуулах, эрсдэлийг шилжүүлэх үйл ажиллагааг хөндлөнгөөс зохион байгуулж байгаа этгээд болох тул даатгуулагчийн эрсдэл, ашиг сонирхлыг сайтар судалж, тэдгээрийн хэрэгцээ шаардлагад нь нийцсэн үйл ажиллагаа явуулах ёстой. Мөн даатгалын зуучлагч нь харилцагчаа хохироосон, мэргэжлийн бус буруутай үйл ажиллагаа явуулсан тохиолдолд хариуцлага хүлээлгэх шаардлага, хэм хэмжээг хуулиар нарийвчлан зааж өгөх шаардлага үүссэн.

Иймд даатгалын зуучлагч нь даатгуулагч, харилцагчид тохирох даатгалын бүтээгдэхүүнийг санал болгох үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд даатгагчдын талаар мэдээллээр хангах, эрэлт хэрэгцээ шаардлагыг нь нарийвчлан тодруулсны үндсэн дээр зөвлөгөө, мэдээлэл өгөх, хэлцэлд зуучлах зэргээр мэргэжлийн түвшинд үйлчилгээ үзүүлэх нийтлэг үүрэгтэй байх, түүнчлэн үйлчилгээний доод стандартыг тодорхой болгох, хэрэгжүүлэх хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоог хангах боломжтой байна.

Хуулинд даатгалын төлөөлөгч, зуучлагчийн үүрэг хариуцлагыг тодорхой тусгаагүйгээс⁸ даатгагч, даатгуулагчийн хоорондын гэрээ ойлгомжгүй, хоёрдмол утгатай хийгдэх, ингэснээр даатгуулагчийн эрх ашиг зөрчигдөх зэрэг сөрөг үзэгдлүүд гарах эрсдэлийг бий болгож байна.

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд Монголын даатгалын зуучлагчдын холбооноос ирүүлсэн саналд “Даатгуулагч болон түүний эрх бүхий этгээд нь даатгагчаас нөхөн төлбөр авахаас бусад тохиолдолд аливаа хөлс, шагналыг шууд болон бусад этгээдээр дамжуулан авахгүй байх” гэж Даатгалын тухай хуульд нэмж оруулсан заалтын тухайд “Энэ саналыг дэмжиж байна. Даатгал хөгжихгүй байгаа шалтгаануудын нэг нь энэ юм.” гэсэн байна.

Иймд даатгалын гэрээ байгуулахад зуучлагч, төлөөлөгч нь даатгалын хураамжаас бусад хэлбэрээр аливаа мөнгөн шагнал урамшууллыг авах,

⁸ Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Даатгалын тухай хууль болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд даатгалын төлөөлөгчийн эрх, үүрэг болон даатгалын зуучлагчийн эрх, үүрэг байдаггүй.

даатгуулагч нь даатгалын нөхөн төлбөрөөс бусад хэлбэрээр гэрээ байгуулсны төлөө шан харамж авах зэргийг зөрчилд тооцох шаардлагатай байна.

Мөн төлөөлж эсвэл зуучилж байгуулсан даатгалын гэрээний хүрээнд үүссэн даатгалын тохиолдолд нөхөн төлбөр гаргуулахтай холбоотой аливаа зөвлөгөө өгөхийг хязгаарлах нь даатгагч болон даатгуулагчийн эрх ашгийг тэнцвэржүүлэхэд чухал ач холбогдолтой.

Монгол Улсад 2019-2023 оны жилийн эцсийн байдлаар буюу 5 жилийн хугацаанд даатгалын компаниуд нийт хураамжийн орлогын дунджаар 33.2 хувь бөгөөд нийт 450.0 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжид зарцуулан, давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрт 47.6 тэрбум төгрөгийг авч хохирлын харьцаа дунджаар 10.6 хувьтай байгаа ба дээрх валютын гадагшлах урсгалыг дотоодын зах зээлд шингээх бололцоог хууль, эрх зүйн бодлогын түвшинд тусгах шаардлагатай байна⁹. Үүний тулд нэг талаас дотоодын давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэх, нөгөө талаас даатгагчдыг хамтран ажиллах таатай эрх зүйн орчныг бий болгох, хамтын ажиллагааг дэмжихэд чиглэсэн “хамтын даатгал”-ын зохицуулалтыг хуульд тусгаж өгснөөр дотооддоо даатгалын хураамжийн хэмжээг өсгөх боломж бүрдэх ба эдгээрийг Даатгалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төсөлд мөн тусгаж байгаа билээ. Энэхүү харилцаанд даатгалын зуучлагчдын оролцоо мөн чухал үүрэгтэй учраас даатгалын зуучлагч нь даатгалын үнэлгээ ихтэй даатгалын гэрээг зуучлахад нэг даатгагч дангаар даатгах боломжгүй тохиолдолд дараагийн даатгагчид хамтрах саналыг гаргахыг үүрэг болгох, гадаадын даатгагчтай шууд зуучлахыг тодорхой хэмжээгээр хязгаарлаж, дотоодын даатгагчдыг дэмжих нөхцөлийг бүрдүүлэх боломжтой байгааг харгалзан үзэх боломжтой байна.

2. Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох

Дээр дурдсан нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд дараах асуудлууд голлон анхаарал татаж байна. Үүнд:

- Даатгалын зуучлалын үйл ажиллагаанд тавигдах шалгуур, үйлчилгээний доод хэм хэмжээг нарийвчлан зохицуулж, хуульчлаагүйн улмаас харилцагч, даатгуулагчийн эрх ашиг бүрэн хамгаалагдахгүй байна;
- Даатгалын мэргэжлийн оролцогч гэх нэр томьёо нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг бодитой үнэн зөв илэрхийлэхгүй, зах зээлд оролцогчдыг төөрөгдүүлэхэд хүргэж байна;
- Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа нь даатгагчаас олгосон албан ёсны зөвшөөрөл дээр тулгуурлан явагддаг бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл олгох нь ач холбогдолгүй, илүү шат дамжлагыг бий болгож буй шаардлагагүй зохицуулалт болдог;
- Даатгалын төлөөлөгч, зуучлагч нь мэргэжлийн санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаагийн хувьд даатгуулагчид өгсөн зөвлөгөө, үйл ажиллагааг тодорхой байдлаар баримтжуулдаг тул даатгуулагч хохирсон

⁹ Санхүүгийн зохицуулах хороо, Даатгалын салбарын 2019-2023 оны үйл ажиллагааны нэгдсэн танилцуулгуудаас шаардлагатай тоон мэдээллүүдийг түүвэрлэж, боловсруулав. [Нэгтгэл-2023--ласт.pdf \(frc.mn\)](#) холбоосоор харна уу.

тохиолдолд даатгагч бүхий л хариуцлага, эрсдлийг үүрэх, даатгалын үйл ажиллагааны зарчим алдагдах нөхцөлийг бий болгож болзошгүй байна.

Энэ хүрээнд Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 86/313 тоот тушаалаар байгуулсан хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүдийн гаргасан санал, Санхүүгийн зохицуулах хорооны санал, холбогдох байгууллагуудтай хийсэн уулзалт, зэргийг судалж үзсэн болно.

2.1. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох

Дээр тодорхойлсон цар хүрээтэй холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна гэж үзлээ.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
Даатгагч	Даатгалын мэргэжлийн оролцогчдын үүрэг хариуцлагыг тодорхой болгосноор даатгалын гэрээний чанар сайжрах бөгөөд даатгалын харилцаанд зарим нэг тодорхойгүй байдал арилах, түүнчлэн төлөөлөгчид тавих нөхцөл, шаардлага бүхэлдээ даатгагчид шилжих тул төрийн зохицуулалтад тулгуурлахгүйгээр төлөөлөгчийг чадваржуулах, хөгжүүлэх үйл ажиллагаа сайжрах боломжтой юм.
Даатгуулагч	Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны үүрэг хариуцлагыг тодорхой болгосноор даатгалын гэрээний чанар сайжрах, даатгуулагч, харилцагчийн хувьд даатгалын байгууллагад итгэл нэмэгдэх, мэдээлэл хүртээмж сайжрах, цаашилбал даатгалын зах зээл өргөжихөд түлхэц болно.
Даатгалын хохирол үнэлэгч	Даатгалын хохирол үнэлэгч нь тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулах шаардлагагүй болох ба Даатгалын тухай хуулийн хүрээнд эрх авч, хяналттайгаар үйл ажиллагаагаа явуулснаар хохирол үнэлгээчдийн үйл ажиллагааны цар хүрээ, тоо хэмжээ, мэдлэг чадвар сайжирна.

2.2. Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль нь 2004 онд батлагдан мөрдөгдөж эхэлснээс хойш тодорхой зарчмын шинж чанартай өөрчлөлт ороогүй бөгөөд даатгуулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалахад анхаарах шаардлагатай байна.

Түүнчлэн даатгалын мэргэжлийн оролцогчид зөвхөн даатгалын зуучлагч, хохирол үнэлэгч, төлөөлөгчийг хамруулж ирсний улмаас даатгалын бусад мэргэжлийн оролцогчид болох даатгалын актуарч, андеррайтер, зөвлөх, даатгалын аудитын үүрэг оролцоог хамааруулахгүй байна. Эдгээр нь даатгалын зах зээлийн өргөжин хөгжих, иргэдэд мэдлэг мэдээлэл олгох, эрсдлийг таних, тодорхойлох, үнэлэх үйл ажиллагааг дэмжихэд чухал нөлөөтэй оролцогчид

байдаг. Гадаадын улс орнуудад мөн даатгалын төлөөлөгч, зуучлагч, хохирол үнэлэгч гэсэн гурван этгээдийг зөвхөн даатгалын мэргэжлийн оролцогчид хамааруулдаг практик байхгүй тул гадаад хэл дээр орчуулах, судалгаа хийх, гадны зах зээлийн үзүүлэлтүүдтэй харьцуулалт хийх зэрэгт тодорхой бус, хоёрдмол ойлголт төрүүлэхүйц байдлыг бий болгодог тул судлаач, оюутнууд, зах зээлийн бусад оролцогчдод зөрүүтэй ойлголтыг өгдөг.

Хуулиар даатгалын төлөөлөгч, зуучлагчийн хүлээх үүрэг, хариуцлагыг нарийн тодорхой болгоогүй байдгаас төлөөлөгч, зуучлагч нь мэргэжлийн гэхээсээ илүүтэй борлуулагчийн үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд чанаргүй даатгалын гэрээ байгуулах, гэрээ байгуулсны төлөө шан харамж авах зэргээр даатгуулагчийг хохироох сөрөг үзэгдлүүд бий болж байна.

Даатгалын хохирол үнэлэх үйл ажиллагааны зохицуулалтыг Даатгалын тухай хуулийн хүрээнд зохицуулахаар төсөлд тусгасан.

Даатгалын хохирол үнэлгээний үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл бүхий компаниуд явуулж байгаа боловч хохирлын үнэлгээг мэргэжлийн бус этгээд хийх боломж нөхцөл бүрдсэн, тодорхой зохицуулалт, шаардлага сул байгаагаас даатгуулагч хохирох байдал зах зээлд үүсч байна.

Даатгалын хохирлын үнэлгээг даатгалын тохиолдол бүрт хийх шаардлагагүй байдаг ба зарим тохиолдолд даатгагч, даатгуулагч нь үнэлгээг урьдчилан тохиролцох боломжтой байдаг. Мөн түүнчлэн даатгалын хохирлын үнэлгээг холбогдох мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байгаа засварын газар, эмнэлэг, дэлгүүр зэрэг этгээдүүд нь зах зээлийн үнэлгээг түргэн шуурхай илүү бодитоор гаргах боломжтой байдгийг харгалзаж үзэх шаардлагатай байгаа болно.

Иймд даатгалын үйл ажиллагаанд даатгагч, даатгуулагчийн эрх ашгийг тэнцвэржүүлэх хүрээнд дундын оролцогчид болох төлөөлөгч, зуучлагчийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлага үүсээд байна.

3. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал

Даатгалын зуучлалын тухай хуулийн төслийг боловсруулах зорилго нь даатгагч, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд дундын оролцогчдын эрх, үүргийг тодорхой болгох, даатгалын төлөөлөгч¹⁰, даатгалын брокер¹¹, банк-зуучлагч¹²-ийн үйл ажиллагааг зохицуулах, даатгалын төлөөлөгч нь даатгагчийг төлөөлж байдаг тул тусгай зөвшөөрөл олгож байгааг өөрчлөх, даатгалын

¹⁰ **Даатгалын төлөөлөгчид** ерөнхийдөө даатгалын компаниудын өмнөөс бизнес эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байдаг. Төлөөлөгчид даатгалын үйл явцад даатгагчийг төлөөлдөг бөгөөд ихэвчлэн даатгагчтай байгуулсан гэрээний дагуу үйл ажиллагаагаа явуулдаг.

¹¹ **Даатгалын брокер /Insurance broker/** - Даатгалын брокерууд даатгалын үйл явцад даатгуулагчийн өмнөөс ажилладаг бөгөөд даатгуулагчидтай холбоотой бие даан ажилладаг. Брокерууд үйлчлүүлэгчиддээ даатгуулагч, бүтээгдэхүүний хувьд өөр хувилбар санал болгож даатгалаа сонгоход нь тусалдаг. Брокерууд янз бүрийн даатгагчаас үнийн саналыг авч, үйлчлүүлэгчдэд олон төрлийн бүтээгдэхүүнээс зохих бодлогыг тодорхойлоход чиглүүлдэг.

¹² **Банк-зуучлагч** - өөрийн харилцагчдад даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг зуучлах, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх банкийг хэлнэ.

хохирлын үнэлгээнд салбарын мэргэжлийн байгууллагын оролцоог дэмжих зорилгоор холбогдох хуулиар буюу Даатгалын тухай хуулиар зохицуулах, даатгалын зуучлагчдын¹³ үйл ажиллагаагаар дамжуулан дотоодын зах зээлийг хөгжүүлэх, хамгаалах, олон нийтийн дунд даатгалын талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах зэрэгт оршино.

4. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулсан байдал

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “даатгагч, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд дундын оролцогчдын эрх, үүргийг тодорхой болгох, даатгалын төлөөлөгч нь даатгагчийг төлөөлж байдаг тул нэмэлтээр тусгай зөвшөөрөл олгож байгааг зогсоох, даатгалын зуучлагчийн үйл ажиллагаагаар дамжуулан дотоодын зах зээлийг хөгжүүлэх, хамгаалах, олон нийтийн дунд даатгалын талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

№	Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1.	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа шийдвэрлэх асуудал, бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй	Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг
2.	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд хууль тогтоомж хоорондын хийдэл, зөрчил арилахгүй.	Ухуулга, сурталчилгаатай холбоотой зардал гарах ба энэ нь олон нийтийн даатгалын талаарх мэдлэгийг зарим талаар нэмэгдүүлэх үр нөлөөг авчирч болох ч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг	Тодорхой үр дүнд хүрэхгүй.

¹³ Даатгалын зуучлагчдын үүрэг

Бүтээгдэхүүн, үнэ, үйлчилгээ үзүүлэгчид зэрэг даатгалын зах зээлийн талаар өргөн мэдлэгтэй, даатгалын худалдан авагчдын эрэлт хэрэгцээг мэдэрдэг тоглогчдын хувьд зуучлагч нь даатгалын зах зээлд онцгой үүрэг гүйцэтгэдэг. Зуучлагчийн үйл ажиллагаа нь нийт эдийн засагт үндэсний болон олон улсын түвшинд аль алинд нь ашиг тусаа өгдөг. Даатгалын эрсдлээс хамгаалахгүй байснаар арилжааны үйл ажиллагаа удааширч, зарим нь зогсоход хүрч ингэснээр эдийн засгийн өсөлтийг бий болгож буй бизнес эрхлэгчид, хувь хүмүүст санхүүгийн үр өгөөжийг зогсоох юм.

			бууруулж чадахгүй.	
3.	Захиргааны шийдвэр гаргах	Даатгалын үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмыг баталж тодорхой асуудлуудыг шийдвэрлэж болох хэдий ч зарим нэг зорилгыг хуульчлах шаардлагатай. Иргэдийн эрх ашгийг бүрэн хамгаалж чадахгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, зорилгод тусгагдсан үр дүнд хүрэх боломжгүй.	Шаардлагатай үр дүнд хүрэхгүй.
4.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Даатгалын үйл ажиллагаанд тулгамдаад байгаа бэрхшээл, асуудлыг шийдвэрлэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	Зардал хэмнэж*, үр ашгийг нэмэгдүүлэх бөгөөд энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй

*Даатгалын төлөөлөгчдөд тусгай зөвшөөрөл олгохгүй болсноор Зохицуулагч байгууллагын ачаалал буурч, үйл ажиллагааны болон санхүүгийн үр ашиг дээшилнэ; Даатгалын компаниудын хувьд нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн удирдлага сайжрах, төлөөлөгч, зуучлагчдын эрх үүрэг тодорхой болж, мэргэжлийн болон хариуцлагатай байдал нь нэмэгдсэнээр даатгуулагчдын даатгалын талаарх мэдлэг сайжирч, даатгалын үйлчилгээнээс авах сэтгэл ханамж дээшилнэ, даатгалын төлөөлөгч болон зуучлагчдын мэргэшсэн байдал сайжирна.

Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдал

Сонгосон хувилбарын зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцааны эерэг, сөрөг талыг харьцуулан судалбал:

Хууль, тогтоомж боловсруулах аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа. *Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.*

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хүний эрх, эрх чөлөөнд сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Даатгалын салбарын эдийн засагт үзүүлэх үр нөлөө дунд болон урт хугацаанд сайжрах бөгөөд иргэдийн хувьд даатгуулах сонирхол нэмэгдсэнээр иргэд, аж ахуйн нэгжийн санхүүгийн баталгаа сайжирна.

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, даатгалын үйл ажиллагаанд итгэх иргэдийн итгэл нэмэгдэнэ.

4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Сонгосон хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, бусад хуультай бүрэн нийцэж байгаа болно.

5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт

Аргачлалын 7-д зааснаар хувилбарын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, Олон улсын хэм хэмжээний жишиг зэргийг харьцуулан дүгнэхэд дурдсан асуудлуудыг хууль боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой юм.

6. Олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа

Бусад улс орны хуулийн онцлох зохицуулалтууд

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуультай улс орон судалгааны үр дүнд гараагүй. Харин Даатгалын зуучлалын тухай бие даасан хуультай дараах улс орнууд байна:

1. Insurance Intermediaries Act 1994 – Шинэ Зеланд – **акт**
2. Financial Advisory and Intermediary Services Act 37 of 2002 – Өмнөд Африк – **акт**
3. Law of the russian federation - 1992 - Law - Insurance Agents and Insurance Brokers – ОХУ – **хууль**
4. Insurance Brokers (Registration) Act - 1977 - Insurance brokers - Их Британи – **акт**

Даатгалын зохицуулалтын ерөнхий хуульдаа болон багц дүрэм журмаараа даатгалын зуучлалын /intermediary/ үйл ажиллагааг зохицуулсан дараах улс орнууд байна:

5. Directive (EU) 2016/97 of the European parliament and of the council of 2016 – Европ– **зөвлөмж**
6. Insurance Business Act (Act No. 105 of June 7, 1995) – Япон – **акт**
7. The Insurance Law of the People's Republic of China 2009– Хятад - **хууль**
8. Insurance Act 1938 (Insurance Act) – Энэтхэг – **акт**
9. Enforcement decree of the insurance business act 2011 – Солонгос – **акт**
10. Cap.41 Insurance Ordinance 1983 – Хонг Конг – **журам**

Дээрх 10 улс орноос Шинэ Зеланд, Өмнөд Африк, ОХУ-д даатгалын зуучлалын талаар тусдаа зохицуулалттай байна. Мөн Шинэ Зеланд, Өмнөд Африк, Их Британи улсууд даатгалын зуучлалын зохицуулалтыг Даатгалын зуучлалын тухай акт, ОХУ-д Даатгалын төлөөлөгч болон брокеруудын тухай хуулиар тус тус зохицуулжээ.

Европын холбооны улсууд, Япон, Хятад, Энэтхэг, Солонгос, Хонг Конг орнуудад даатгалын зуучлагчдын тухай тусдаа зохицуулсан хууль байхгүй бөгөөд даатгалын тухай хуулиараа даатгалын зуучлалыг зохицуулдаг байна.

Нарийвчилсан зохицуулалтын талаар зарим улсын хувьд судалж үзэхэд дараах байдалтай байна:

Герман улс¹⁴

Даатгалын төлөөлөгч, зуучлагчийн үйл ажиллагааг Даатгалын тухай хуулиар зохицуулсан байдаг.

Герман улсын хуулиар төлөөлөгч нь даатгагчийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах бөгөөд гэрээний дагуу даатгалын гэрээ байгуулах эрхтэй этгээд гэж тодорхойлсон байдаг. Иймд төлөөлөгч нь зохицуулах байгууллагаас зөвшөөрөл авах шаардлагагүй байдаг боловч бүртгүүлэх үүргийг хуульчилсан байдаг. Даатгалын төлөөлөгчийн хувьд төлөөлж буй даатгагчийн нэрийг заавал дурдах үүрэгтэй бөгөөд тухайн даатгалын бүтээгдэхүүн, мэдээллийн сурвалжийн талаар мэдэгдэх үүрэгтэй.

Харин зуучлагч нь даатгагчтай гэрээ байгуулж ажилладаггүй бөгөөд даатгалын бүтээгдэхүүнийг мэргэжлийн түвшинд зуучлах үйл ажиллагааг явуулдаг. Даатгалын брокер, зөвлөгөө үзүүлэгч нь мэргэжлийн түвшинд үйл ажиллагаа явуулах ёстой бөгөөд зах зээл дээрх хэд хэдэн бүтээгдэхүүнийг харьцуулах, тухайн харилцагчид аль бүтээгдэхүүн тохиромжтой талаар санал гаргах, хүндрэлтэй нөхцөлд тухайн этгээдийн хүсэл, сонирхлын талаар тодруулах үүрэгтэй болохыг тусгасан. Мөн түүнчлэн өгсөн зөвлөгөө, үндэслэлийг бичгээр баталгаажуулан зуучлуулагчид өгөх үүрэгтэй бөгөөд зуучлуулагч бичгээр зөвшөөрсөн тохиолдолд өгсөн зөвлөгөөг баримтжуулах үүргээс чөлөөлөгддөг

¹⁴ Герман улсын Даатгалын гэрээний тухай хууль, <https://germanlawarchive.iuscomp.org/?p=861#I7> холбоосоор харна уу.

байна. Энэхүү үүргээ хангалттай биелүүлээгүй тохиолдолд зуучлагч нь хохирлыг барагдуулах үүрэг хүлээдэг.

Европын холбооны 2002/92/ЕС захирамжийн дагуу даатгалын бүтээгдэхүүн борлуулах этгээд нь зөвшөөрөл авсан байхыг шаарддаг.

Австрали¹⁵

Брокер болон даатгалын мэргэжлийн оролцогчийг Corporations act-н хүрээнд зохицуулдаг. Тус улсын хувьд 2001 оны Санхүүгийн үйлчилгээний шинэчлэлийн тухай акт (Financial Services Reform Act)-ын дагуу даатгалын бүх зуучлагчид /брокер/ Холбооны Засгийн Газрын Австралийн Үнэт цаас болон хөрөнгө оруулалтын комисс (Australian Securities and Investments Commission)-оос зөвшөөрөл авах шаардлагатай байдаг. Даатгалын брокер нь Үндэсний Даатгалын Брокерын холбооны гишүүн байх шаардлагатай бөгөөд гишүүнчлэлийн гэрээний дагуу брокерын үйл ажиллагаа явуулах дүрмийг мөрдөх үүрэг хүлээдэг. Дүрэмд брокерын үйлчилгээний доод стандартыг тусгасан бөгөөд дүрэмтэй холбоотой гомдол маргааныг шийдвэрлэх талаар дурдсан байдаг.

Төлөөлөгч нь ихэвчлэн даатгагчийг төлөөлдөг бол бусад оролцогчдын хувь аль аль талын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг. Даатгагчийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах оролцогчид нь итгэмжлэгдсэн төлөөлөгч эсвэл албан ёсны дистрибьютер хэлбэрээр ажилладаг.

Брокерын хувьд Corporations act-н дагуу санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Харин давхар даатгалын брокер нь зөвшөөрөл авах шаардлагагүй байдаг ба дээрх хуулиар давхар даатгалыг санхүүгийн үйлчилгээнд тооцдоггүй байна.

Австралид санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй даатгагчийн ажилтан, төлөөлөгч нь зөвшөөрөл авах шаардлагагүй. Австралид нэр хүндтэй, туршлагатай даатгалын зуучлагчид ерөнхий даатгал, зуучлалын чиглэлээр гүнзгийрүүлэн судалж санхүүгийн үйлчилгээний гэрчилгээ, диплом авах шаардлагатай байдаг. Мөн мэргэжлийн сайн дадлага, үнэнч шударга байдал, орчин үеийн ур чадвар, мэдлэгийг эзэмшсэн гишүүдэд мэргэжлийн итгэмжлэл олгодог хэд хэдэн салбарын байгууллагууд байдаг.

Япон улс¹⁶

Даатгалын бизнесийн тухай хуулийн дагуу даатгалын бүтээгдэхүүнийг зөвхөн доор дурдсан этгээдүүд борлуулах эрхтэй гэж заасан.

- Амьдралын даатгалын төлөөлөгч /агент, даатгагчийн ажилтан, албан хаагч/
- Амьдралын бус даатгалын төлөөлөгч /агент, даатгагчийн ажилтан, албан хаагч/
- Жижиг богино хугацааны даатгалын төлөөлөгч
- Даатгалын брокер

¹⁵ Австрали улсын Корпорацийн тухай хууль, 2001, <https://www.legislation.gov.au/Details/C2019C00216/Download> холбоосоор харна уу.

¹⁶ Япон улсын Даатгалын бизнесийн тухай хууль, <https://www.fsa.go.jp/common/law/ins01.pdf> холбоосоор харна уу.

Амьдралын даатгалын компанийн төлөөлөгч, ажилтан, албан хаагч, амьдралын бус даатгалын төлөөлөгч, жижиг богино хугацааны даатгалын төлөөлөгч нар зохицуулах байгууллагад бүртгүүлэх шаардлагатай байдаг бөгөөд тавигдах шаардлагуудыг хангасан байхыг шаарддаг байна. Тус этгээдүүд нь даатгагчийн нэрийн өмнөөс гэрээ байгуулан ажилладаг тул зуучлалын буруутай үйл ажиллагаанаас үүдсэн хохирлыг даатгагч хариуцах үүрэгтэй байдаг байна.

Харин даатгалын брокер нь бие даан үйл ажиллагаа явуулдаг тул зуучлалын буруутай үйл ажиллагаатай холбоотой хариуцлагыг өөрөө үүрдэг. Иймд даатгалын брокер нь зөвшөөрөл авахдаа тодорхой шаардлагуудыг хангасан байх ёстой. Үүнд:

- Нөөц сангийн газарт хөрөнгө байршуулах
- Брокерын хариуцлагын даатгалд хамрагдах
- Бусад

Их Британи улс

Их Британи улсын хувьд даатгалын зуучлагч гэдэг нэр томъёо нь 1977 оны Даатгалын зуучлагчдын тухай актаар зохицуулагджээ. Даатгалын зуучлал нь амьдралын даатгалаас илүүтэй ерөнхий даатгал (автомашин, байшин гэх мэт)-тай холбоотой ч зарим брокерууд 2001 онд шинэ зохицуулалт гарах хүртэл хөрөнгө оруулалт, амьдралын даатгалын зуучлалыг хийдэг байжээ. Зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх төлбөрийг урьдчилж тохиролцох үндсэн дээр илүү ил тод зохицуулалтыг бий болгох шаардлагатай болсон бөгөөд шинэ зохицуулалтаар зуучлагчдыг амьдралын даатгал, хөрөнгө оруулалт, тэтгэврийн бие даасан санхүүгийн зөвлөхүүд болон ерөнхий даатгалын зуучлагчид гэсэн хоёр бүлэгт хуваадаг байна. Өнөө үед ерөнхий даатгалын зуучлалыг уламжлалт брокерууд, утас вэбд суурилсан компаниуд гэх мэт олон төрлийн байгууллагууд эрхэлдэг. Британийн даатгалын зуучлагчдын холбоо нь Англи улсын брокеруудын төлөөллийн байгууллага бөгөөд 1800 гаруй гишүүнтэй.

Шинэ Зеланд улс

Шинэ Зеландын зохицуулалт нь Санхүүгийн Зах зээлийн газраас хяналт тавьж ажилладаг бөгөөд Санхүүгийн зөвлөхүүдийн тухай 2008 оны хуулийн¹⁷ дагуу даатгалын зуучлагч зэрэг санхүүгийн бүх зөвлөхүүдэд зориулсан мэргэжлийн стандартыг тогтоодог. Мөн брокерууд даатгалын зуучлагчдын тухай 1994 оны хуулийг¹⁸ дагаж мөрдөх ёстой бөгөөд хураамж болон бусад мөнгөн хөрөнгийг хэрхэн яаж зохицуулж, тооцохыг зохицуулдаг. Брокеруудад 1994 оны Даатгалын зуучлагчийн тухай хуульд Даатгалын зуучлагчдад төлөх төлбөр, шимтгэлтэй холбоотой брокеруудын үүрэг, Даатгуулагчид төлөх төлбөртэй холбоотой брокеруудын үүрэг зэрэг багтдаг бол 2008 оны Санхүүгийн зөвлөхүүдийн тухай хуульд Брокеруудын тодруулга ба үүрэг, зохицуулалтын талаар бичигдсэн байна.

¹⁷ Шинэ Зеланд улсын Санхүүгийн зөвлөхүүдийн тухай 2008 оны хууль - <https://www.legislation.govt.nz/act/public/2008/0091/latest/whole.html>

¹⁸ Шинэ Зеланд улсын даатгалын зуучлагчдын тухай 1994 оны хууль - <https://www.legislation.govt.nz/act/public/1994/0041/latest/DLM331829.html>

Оросын холбооны улс

ОХУ-ын 1992 оны 4015-1 дугаар бүхий Даатгалын бизнесийн зохион байгуулалтын талаар хуулийн¹⁹ 8-р зүйлд Даатгалын төлөөлөгчид ба даатгалын брокеруудын талаар зохицуулагддаг. ОХУ-ын даатгалын зах зээл дээр зуучлах ажлыг даатгалын төлөөлөгчид эсвэл брокерууд хийж болно. ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу даатгалын брокер ба төлөөлөгчийн ялгаа нь брокер даатгагчийн зааврын дагуу үйл ажиллагаа эрхлэхийг хориглодог бол төлөөлөгч нь даатгуулагчийн зааврын дагуу үйл ажиллагаа явуулахыг хориглодог. Нэмж дурдахад брокерууд ОХУ-ын Төв Банкнаас эрх авах ёстой бөгөөд харин төлөөлөгчдөд эрх шаарддаггүй. ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу брокер, төлөөлөгчийн үйл ажиллагааг нэгтгэж болохгүй.

Канад улс

Канад улсын хувьд даатгалын зуучлагчдыг муж, нутаг дэвсгэрийн зарчмаар зохицуулдаг бөгөөд Канадын ихэнх мужид даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгчид нь ижил нэг байгууллагаас эсвэл Даатгалын Ерөнхий Зөвлөл эсвэл засгийн газрын харьяаллын байгууллагаас тусгай зөвшөөрөл авч зохицуулагддаг байна. Онтарио гэх мэт зарим мужуудад даатгалын зуучлагчид тусгай зөвшөөрөл олгож, зохицуулалтыг хариуцдаг өөрөө удирдах байгууллагатай байдаг байна.

Америкийн нэгдсэн улс

АНУ-д даатгалын зуучлагчдыг муж бүрээр ялгаатай зохицуулдаг. Ихэнх мужид даатгал зардаг, санал болгодог эсвэл гэрээ хэлэлцээр хийж буй аливаа этгээд даатгалын зуучлагчийн зөвшөөрөл авахыг шаарддаг. Үүнд аж ахуйн нэгж, аж ахуйн нэгжийн албан тушаалтнууд эсхүл захирлууд, бие даасан ажилтнууд орно. Даатгалын зуучлагчийн зөвшөөрөл авахын тулд сургалтад хамрагдаж, шалгалт өгч, бүх шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлж, найдвартай чадварлаг болохыг тодорхойлдог. Зарим муж улсууд өргөдөл гаргагчдаас хурууны хээ өгөхийг шаарддаг. Зөвшөөрөл авсны дараа даатгалын зуучлагч нь сунгуулах өдөр хүртэл тасралтгүй боловсролын сургалтад хамрагдах ёстой. Ихэнх мужууд харилцан үйлчлэх гэрээ байгуулдаг бөгөөд үүгээрээ нэг мужийн зуучлагчид өөр мужид амархан зөвшөөрөл авах боломжтой байдаг. Холбооны улсын Gramm-Leach-Bliley Акт-ын үр дүнд ихэнх мужууд зөвшөөрлийн нэгдсэн актыг баталж, 47 мужийг Даатгалын Комиссаруудын Үндэсний Ассоциаци (National Association of Insurance Commissioners)-аас харилцан тохиролцсон гэж үзсэн. Даатгалын зуучлагч нь компаниуд болон хувь хүмүүст эд хөрөнгө, амь нас, аннуити, аваар осол, эрүүл мэндийн даатгалыг худалдан авахад нь туслахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Зуучлагчид даатгал худалдан авахаас гадна эрсдэлийг үнэлэх, даатгалын зөвлөх үйлчилгээ, даатгалтай холбоотой зохицуулалт, хууль тогтоомжийн шинэчлэлт, нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн тусламжийн үйлчилгээ, ажилчдын бүртгэлд туслалцаа үзүүлэх, тэтгэмжийн асуудлыг шийдвэрлэхэд туслах зэрэг үйлчилгээ үзүүлдэг.

¹⁹ ОХУ-ын даатгалын бизнесийн зохион байгуулалтын талаар хууль - https://www.wto.org/english/thewto_e/acc_e/rus_e/WTACCRUS58_LEG_395.pdf

Солонгос улс

Солонгос улсад даатгалын төлөөлөгч Санхүүгийн хяналтын алба (FSS)-нд бүртгүүлсэн байх ёстой. Бүртгэлд Солонгосын Даатгалын Хүрээлэнгийн сургалтад хамрагдан, шалгалт өгч тэнцсэн баримт шаарддаг.

Доорх нөхцөлд даатгалын төлөөлөгчөөр бүртгэхгүй:

- Даатгалын төлөөлөгчөөр мэргэшээгүй хүн
- Даатгалын борлуулалтын зөвлөх, даатгалын зуучлагчаар бүртгүүлсэн хүн
- Бусад даатгалын компанийн ажилтан
- Өрсөлдөөнийг хязгаарлах гэх мэт аливаа шударга бус үйл ажиллагаанд оролцох магадлалтай хүн

Кени улс ²⁰

Даатгалын тухай хуульд заасны дагуу даатгалын төлөөлөгч Даатгалын зохицуулах газарт заавал бүртгүүлэн, зөвшөөрөл авах шаардлагатай. Өргөдөл гаргагч дараах баримтыг хүсэлтэд хавсаргана:

- Өргөдөл гаргагч нь Даатгалын коллежийн зохион байгуулдаг даатгалын төлөөлөгчийн мэргэжлийн ур чадварын сургалтад хамрагдан, шалгалтад тэнцэж, гэрчилгээ (COP) авсан байх ёстой.
- Иргэний харьяаллыг нотлох баримт бичиг
- Өргөдөл гаргагч төлөөлөгчөөр ажиллах компанид шаардлагатай мэдлэг, туршлагатай болохыг нотолсон санал
- Даатгалын төрлийг тусган, нэрийг нь бүртгэсэн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар
- Бүртгэлийн хураамжийг Даатгалын зохицуулах газарт төлнө
- Корпорацын төлөөлөгчийн хувьд өргөдөл гаргасан даатгалын төрлийг тусгасан аж ахуйн нэгжийн нэрийг бүртгэсэн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар эсвэл үүсгэн байгуулах гэрчилгээ, дүрэм, журмын хуулбар, хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй мэдээлэл

Олон улсын даатгалын зохицуулагч байгууллагуудын холбоо /IAIS/

Олон улсын даатгалын зохицуулагч байгууллагуудын холбоо /IAIS/-с боловсруулан баталсан Даатгалын тулгуур зарчмуудын /ICP/ 18 болон 19-өөр даатгалын зуучлагч, даатгалын бизнесийн ёс зүйн талаар тодорхой тусгасан байна.

Тодруулбал: Даатгалын зуучлагч хэмээх 18 дугаар зарчимд даатгалын зуучлагч нь тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулдаг байх, хянан шалгалтад хамрагддаг

²⁰ Кени улсын даатгалын төлөөлөгчийг бүртгэх талаар мэдээлэл - [Insurance Regulatory Authority \(ira.go.ke\)](http://ira.go.ke)

байх, мэргэжлийн мэдлэг, туршлага, ур чадварыг зохих түвшинд эзэмшсэн байх, зохистой засаглал хэрэгжүүлдэг байх, тайлан мэдээллээ олон нийтэд хүргэдэг байх, хэрэглэгчдийн мөнгөн хөрөнгийн аюулгүй байдлыг хангах, албадлагын арга хэмжээ авах зохицуулалттай байх зэрэг зарчмуудыг тусгасан байна.

Бизнесийн ёс зүй гэсэн 19 дүгээр зарчимд даатгалын гэрээ байгуулахын өмнө болон дараа нь хэрэглэгчдэд зохистой хандах, гэрээнд тусгасан үйлчилгээгээ бүрэн дүүрэн үзүүлэх, хэрэглэгчидтэй мэргэжлийн түвшинд, ойлгомжтой найрсаг, шударга харьцах, хэрэглэгчийн нөхцөл байдалд тохирсон, зохистой зөвлөгөө өгдөг байхыг шаардана. Ийнхүү зөвлөгөөг өгөх явцдаа ямар нэг ашиг сонирхлын зөрчилгүй байхыг шаарддаг байна.

Мөн бизнесийн харилцааны бодлого, журамтай байх, хэрэглэгчдэд борлуулалт хийх цаг хугацаа, хүргэлт, өгөх мэдээллийн агуулгад тавих шаардлагыг тогтоох, хэрэглэгчийн хувийн мэдээллийг хамгаалах бодлого, журамтай байхыг шаардана.

7. Зөвлөмж

Монгол Улсын төрийн бодлого, даатгалын салбарыг хөгжүүлэх зорилтын хүрээнд даатгалын салбарыг хөгжүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зохицуулах байгууллагын хяналт оролцооны зохистой түвшинг хангах, даатгалын салбарт оролцогчдын эрх зүйн байдлыг тодорхой болгох зорилгоор даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах урьдчилан тандан судлах ажлыг гүйцэтгэлээ.

Харьцуулалтын үр дүнг харгалзан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь зорилгод хүрэх боломжтой оновчтой хувилбар гэж дүгнэж байна.

---oOo---